

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн
хуралдааны 2024 оны 12 дугаар сарын
20-ны өдрийн 43 дугаар тогтоолын хавсралт

МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журам нь мэргэжлийн нэгдсэн холбоо (цаашид МНХ гэх)-г үүсгэн байгуулсныг Улсын дээд шүүхэд бүртгүүлэх, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

1.2.МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны (цаашид Нийт шүүгчийн хуралдаан гэх) дэг болон энэ журмыг удирдлага болгоно.

1.3.МНХ-г үүсгэн байгуулснаас бусад асуудлаар Улсын дээд шүүх бүртгэл хийхгүй.

Хоёр.Хүсэлтийг хүлээн авч, хуваарилах, бэлтгэл ажиллагаа

2.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн (цаашид хуулийн гэх) 6 дугаар зүйлийн 6.2-т заасан этгээд МНХ-г үүсгэн байгуулсныг Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг (Хавсралт № 1, 1А)-д заасны дагуу гаргах бөгөөд Бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авснаас хойш 1 хоногийн дотор Бүртгэлийн албанд холбогдох журмын дагуу шилжүүлнэ.

2.2.Бүртгэлийн алба хүсэлт, түүнд хавсарган ирүүлсэн баримт бичгийг энэ журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу шалгаж, хуудасны тоог бүртгэлд тусган, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгүүлэх хүсэлт гаргахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлнө.

2.3.Бүртгэлийн алба хүсэлт, хавсаргасан баримт бичгийн бүрдэл болон хугацаа хэтрүүлсэн эсэхийг шалгаж, бүрдэл дутуу бол зөрчлийг арилгаж, нэмэлт баримт, мэдээлэл ирүүлэхийг хугацаа заан хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

2.4.Хүсэлт бүрдэл хангасан бөгөөд зөрчилгүй гэж үзвэл хүсэлт, холбогдох баримт бичгийг Бүртгэлийн алба тогтоосон журмын дагуу Захиргааны хэргийн танхимд шилжүүлж, танхимаас урьдчилан тогтоосон дарааллын дагуу хүсэлтийг шүүгчид хуваарилна

2.5.Хүсэлтийг хүлээн авсан шүүгч хүсэлт, хавсаргасан баримт бичиг хуульд заасан шаардлага хангасан эсэхийг нягтлан шалгаж, зөрчилтэй гэж үзвэл зөрчлийг арилгаж, нэмэлт баримт, мэдээлэл ирүүлэхийг хугацаа заан хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

2.6.Хүсэлт гаргагч журмын 2.5-д заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй бол Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт шүүгч албан бичгээр буцаана.

2.7.МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгүүлэхтэй холбоотой хэд хэдэн хүсэлт ирсэн бол агуулгаас хамаарч тэдгээрийг нэгтгэн хэлэлцэж болно. Хүсэлтийг

нэгтгэн хэлэлцэх эсэхийг Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

2.8. Шаардлагатай гэж үзвэл хүсэлтийг хүлээн авсан шүүгч тухайн хүсэлт гаргагч, улсын бүртгэлийн байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулж болно.

2.9. Хүсэлтийг хүлээн авсан шүүгч танилцуулга бэлдэж, Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанд танилцуулах ба Захиргааны хэргийн танхимын тэргүүн танилцуулгыг Ерөнхий шүүгчид хүргүүлнэ. Ерөнхий шүүгч хуульд заасан хугацаанд багтаан хүсэлтийг Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар захирамж гаргана.

Гурав. Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хүсэлтийг хэлэлцэх

3.1. МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгүүлэх хүсэлтийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.10, 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд энэ журамд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэгийг баримтална.

3.2. МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгүүлэх хүсэлтийг хэлэлцэх товын талаар Улсын дээд шүүхийн цахим хуудсанд мэдээлнэ.

3.3. МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэх ажиллагаа хүсэлтийг хүлээн авсан шүүгчийн илтгэлээр эхэлж, илтгэгч шүүгч Улсын дээд шүүхэд ирүүлсэн хүсэлтийн агуулга, баримт бичгийн бүрдэл, хуралдааны бэлтгэл хангах хугацаанд явуулсан үйл ажиллагаа зэргийг танилцуулна.

3.4. МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгэх эсэхийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т зааснаар нийт шүүгчийн олонхын саналаар шийдвэрлэх ба шийдвэрийг бичгээр үйлдэж цахим, эсхүл цаасан хэлбэрээр хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

3.5. Хүсэлтийг буцаасан, бүртгэхээс татгалзсан нь хүсэлт гаргагчийн зөрчлөө арилган дахин хандах эрхийг хязгаарлахгүй.

3.6. МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгэхтэй холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндэслэл тогтоогдвол шүүгч татгалзан гарна. Шүүгч өөрөө, эсхүл дээрх үндэслэлээр хүсэлт гаргагч шүүгчээс татгалзсан бол хүсэлтийг Нийт шүүгчийн хуралдаанаар тус тус шийдвэрлэнэ.

Дөрөв. Гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох

4.1. МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгэх тухай Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол гарснаар тухайн МНХ-нд гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаарыг (Хавсралт №2, 3)-д заасан маягтын дагуу олгоно.

4.2. Гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаарыг олгох (Хавсралт №3)-т заасан үйл ажиллагааг Улсын дээд шүүхийн Тамгын газар хэрэгжүүлнэ.

4.3.Нэг МНХ-нд нэг тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох бөгөөд уг дугаарыг МНХ-ны дотоод зохион байгуулалтын салбар нэгжийн тамга, тэмдэгт ашиглаж болно.

Тав.Бусад асуудал

5.1.МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгүүлэх тухай хүсэлт, түүнд хавсаргасан бичгийн болон цахим хэлбэрийн баримтыг зохих бүртгэлд тусгаж хувийн хэргийг нээж, дээрх баримт, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол болон бусад баримтыг хуудас тус бүрээр товъёглон цаасан болон цахим хэлбэрээр хадгална.

5.2.МНХ-г үүсгэн байгуулсныг бүртгэсэнтэй холбоотой бичиг баримтын эхийг түүнийг гаргаж өгсөн этгээд хүсвэл буцаан өгч болно. Харин уг баримтын нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг авч үлдэнэ.

5.3.МНХ-г бүртгэхээс татгалзсан тохиолдолд хүсэлт болон түүнд хавсарган ирүүлсэн баримтуудыг хуулбарлан авч үлдэн жагсаалтаар хүсэлт гаргагчид буцаан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулсан баримтын хамт хадгална.

5.4.МНХ-ны улсын бүртгэлийн гэрчилгээ ашиглах боломжгүйгээр элэгдэж хуучирсан, гэмтсэн, устсан, хаяж үрэгдүүлсэн бол гэрчилгээг дахин авах хүсэлт холбогдох журмын дагуу гаргаж болно. Гэрчилгээ дахин олгох эсэхийг Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэн хүсэлтийг хангасан тохиолдолд гэрчилгээг дахин олгоно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг хуульд заасан журмын дагуу төлнө.

5.5.МНХ-ны үүсгэн байгуулагдсан бүртгэлийн талаар лавлагаа авах, МНХ-ны хувийн хэргээс бичиг баримт хуулбарлах, МНХ-ны хувийн хэрэгтэй танилцах зэрэг асуудлаар гаргасан хүсэлтийг Захиргааны хэргийн танхимын тэргүүн болон Тамгын газрын даргад танилцуулснаар Бүртгэлийн алба хэрэгжүүлнэ.

5.6.Бүртгэлийн алба МНХ-ны үүсгэн байгуулсныг бүртгэсэн бүртгэлийн мэдээлэлтэй холбоотой үг, үсэг, тоо зэрэг техникийн шинжтэй өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлж болно.

---o0o---



МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООГ ҮҮСГЭН
БАЙГУУЛСНЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ

1. Хүсэлт гаргасан он, сар, өдөр:

2. Мэргэжлийн нэгдсэн холбооны бүтэн болон товчилсон нэр:

3. Хүсэлтийн агуулга:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

4. МНХ-ны хаяг, утасны дугаар:

5. Хүсэлт гаргах эрх бүхий этгээд:

5.1. МНХ-ны ерөнхийлөгчийн талаарх мэдээлэл:

Д/д	Овог	Нэр	Утасны дугаар	Гарын үсэг
1.				


5.2. МНХ-ны удирдах зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээлэл:

Д/д	Овог	Нэр	Утасны дугаар	Гарын үсэг



МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООГ ҮҮСГЭН
БАЙГУУЛСНЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТИЙН ХАВСРАЛТ

- 1.Хүсэлт:
- 2.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах тухай шийдвэр, хурлын тэмдэглэл
(шийдвэр болон хурлын тэмдэглэлд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан байна)
- 3.Мэргэжлийн нэгдсэн холбооны бүтэн болон товчилсон нэр:
.....
- 4.Мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм
- 5.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүдийн бүртгэл
(гишүүдийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг)
- 6.Тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй байхыг нотолсон баримт бичиг
- 7.МНХ-ны гишүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт нь тухайн салбарын зах зээлийн 50-аас дээш хувийг эзэлдэг байхыг нотолсон баримт бичиг
8. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
9. Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл



ГЭРЧИЛГЭЭ, ТАМГА, ТЭМДГИЙН ХЯНАЛТЫН
ДУГААР АВАХ ХҮСЭЛТ

... он ... сар ... өдөр

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны нэр:

--

2.МНХ-ны регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

3.Гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын
дугаар авах үндэслэл:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

4.Хүсэлт гаргагчийн мэдээлэл:

Овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:


Регистрийн дугаар:

Утасны дугаар:

Эрхэлж буй ажил:

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/



ТАМГА, ТЭМДГИЙН ХЯНАЛТЫН ДУГААР ОЛГОХ
БҮРТГЭЛИЙН ХУУДАС

.....он.....сар.....өдөр

1.МНХ-ны бүтэн болон товчилсон нэр:

2.МНХ-ны регистрийн дугаар:

3.Тамга, тэмдгийн хяналтын дугаар:

4.МНХ-ны хяналтын дугаар олгох үндэслэл:

.....
.....
.....

ДАРГА _____

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

ТАМГА, ТЭМДГИЙН ҮЙЛДВЭРЭЭС УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД
БУЦААХ /ТАЙЛАГНАХ/ ХЭСЭГ

1.МНХ-ны нэр:

2.МНХ-ны регистрийн дугаар:.....

3.Тамга, тэмдгийн өнгө, загвар:.....

.....


4.Тамга, тэмдэг захиалсан этгээдийн эцэг /эх/-ийн нэр,
өөрийн нэр, утасны дугаар:

.....

5.Тамга, тэмдэг үйлдвэрлэсэн хуулийн этгээдийн нэр:

.....

6. Тамга, тэмдэг үйлдвэрлэсэн он, сар, өдөр:



Үйлдвэрлэгчийн гарын үсэг:

/Гарын үсэг, тэмдэг/

/ _____ /

/Гарын үсгийн тайлал/